

**“АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Д.ТҮВШИНТАМИРЫН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 04 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот


Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 01 дүгээр улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд нийт 7 удаа хуульд заасны дагуу танхимаар, цахим хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс дараах тогтоол, шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнд:

1. 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын товыг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гэж тогтоох тухай асуудлыг хэлэлцэж батлав.
2. 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ХЭЭБХ-ын товыг Ариг банкны дүрэмд "... ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө товлох" гэж заасны дагуу 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагт товлох саналыг бүх гишүүд дэмжин оролцсон. ХЭЭБХ-аар хэлэлцэх дараах асуудлуудыг тогтоосон болно. Үүнд:
 1. "Ариг банк" ХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах;
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг нөхөн олгох.
3. 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:
 1. 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн ХЭЭБХ-ын ирц бүрдээгүй тул ээлжит бус хурлын товыг тогтоох;
 2. Хувьцаа эзэмшигч "Улаанбаатар Импэкс" ХХК-ийн хувьцаа худалдан авах саналыг ирүүлсэнтэй холбогдох асуудлыг хэлэлцэх, ирүүлсэн материалыг Монгол Банкруу хүргүүлэх, "Хувь нийлүүлсэн хөрөнгийг байршуулсан гэрээ"-нд Ариг банкныг төлөөлөн гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг томилох;
 3. "Голден пропертиз" ХХК-тай байгуулах "Хамтран ажиллах гэрээ"-ний хүрээнд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах эрхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчид олгох;
 4. "Century 21 Mongolia" үл хөдлөх хөрөнгө зуучлалын компанитай хамтран ажиллах сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх зөвшөөрлийг олгох эсэх асуудлуудыг тус тус хэлэлцэв.
4. 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:
 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг 2022 оны 04 дүгээр сарын 20 өдрөөр тогтоох;
 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцэхээр баталсан болно. Үүнд:
 - "Ариг банк" ХХК-ийн 2021 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах, Хувьцаа эзэмшигчдэд дүгнэлтийг танилцуулах;
 - Ноогдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэх;
 - "Ариг банк" ХХК-ийн 2022 оны төсвийг хуваарилах;

- Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хэлэлцэх;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай.
5. 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:
 1. Ариг банкны 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
 2. Ариг банкны 2021 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;
 3. Ариг банкны 2022 оны санхүүгийн төсвийг хэлэлцэж батлах;
 4. "Ариг банк" ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх буюу Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар танилцуулга бэлтгэх;
 5. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой асуудал.
 6. 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:
 1. Монгол банкны журмын дагуу Ариг банкны тогтворжуулах төлөвлөгөөг гаргаж, Эрсдэлийн хороогоор хэлэлцүүлсний үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж батлуулах;
 2. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариунжаргалын хүсэлтийг шийдвэрлэх;
 3. "Номин даатгал" ХХК-тай сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар хэлцэл хийх тогтоолын төслийг батлах;
 4. "МВАРМ" ХХК-ийн хувьцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх.
 7. 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг цахимаар явуулж, хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:
 1. "Ариг банк" ХХК-ийн "Тогтворжуулах төлөвлөгөө"-г хэлэлцэн баталж, Монгол банкинд хүргүүлэх тухай;
 2. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариунжаргалын хүсэлтийн дагуу түүний чөлөөний хугацааг сунгах тухай;
 3. "Ариг банк" ХХК-ийн нэмж гаргасан хувьцаатай холбогдох саналын мэдэгдлийг "Улаанбаатар импекс" ХХК-д хүргүүлэх тухай асуудал;
 4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын товыг тогтоох.

Түүнчлэн "Ариг банк" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хорооны даргаар Д.Түвшинтамир миний бие ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Эрсдлийн удирдлагын хороо нь "Ариг банк" ХХК-ийн "Тогтворжуулах төлөвлөгөө"-г хэлэлцэн хянаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

 Д.Түвшинтамир